



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/174

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалтад зарцуулах зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалтын ажилд зарцуулах 50,000,000 (тавин сая) төгрөгийн захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

3. Ногоон байгууламжийн ажилд зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн дарга (А.Ганболд), ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалт төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

5. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010133

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 22-ны өдрийн 1/А дугаар
захиамжийн хавсралт



**Булган сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг
нэмэгдүүлэх ажлын зардлын хуваарь**

№	Хийгдэх ажлын нэр	Батлагдсан төсөвт өртөг (төгрөг)	Гүйцэтгэх албан тушаалтан
1	2	3	4
1	Нарс модны усалгаа арчилгаа	4,620,000.0	Тохижилт үйлчилгээний ангийн дарга А.Ганболд
2	Зүлэгжүүлэх усалгаа арчилгаа	16,200,000	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
3	Цэцэгжүүлэх усалгаа арчилгаа	21,000,000	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
4	Цэнгэлдэх хүрээлэнгийн зүлэгний усалгаа арчилгаа	4,000,000	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
5	Ажиллах хүчний зардал	4,200,000	Тохижилт үйлчилгээний ангийн дарга А.Ганболд